

тариалан, мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хүсэл сонирхолтой иргэдтэй төрийн зүгээс дэмжиж, хамтарч ажиллах боломжтой.

Сум, орон нутгийн хэмжээнд өндөр ашиг шимтэй шилмэл үүлдрийн малыг өсгөн үржүүлж, модон бүтээгдэхүүний түүхий эдийг нийлүүлэх, даршилж нөөшилсөн хүнсний ногооны бэлдэц зэргийг бэлтгэн зах зээлд нийлүүлэн тухайн чиглэлийн бизнесийн үйл ажиллагааг хөгжих боломжийг бий болгон ажилладаг



- Олон улсын санхүүжүүлэгч байгууллагын дэмжлэгтэйгээр “Адра”, “Стрийм”, “Ногоон хэрэм”, улсын төсвийн болон ААНэгжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй нөхөн сэргээлт, ойжуулалт, тарьц, суулгац үйлдвэрлэлийн төслүүд хэрэгждэг. Эдгээр төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд ажлын байраар хангагдах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх чиглэлээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, амьжиргааны баталгаажих түвшингээ дээшлүүлэх боломжтой.



- Төрийн захиргааны албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг Засгийн газрын тогтоолоор 20%, Аймгийн Засаг даргын захирамжаар 30%, сумын ИТХ-ын тогтоолоор 30% нийт 80 хувиар олгож байна. Мөн төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 80 хувиар тус тус нэмэгдүүлэн олгож байна.



Ерөө сум



99245745



<https://eruu.se.gov.mn/>



# НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ



“СЭЛЭНГИЙН ИРЭЭДҮЙ- ТОГТВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ”

## СУМ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ:

Ерөө сум 1924 онд Түшээт хан аймгийн Эрдэнэ чин вангийн хошууны Хүдрийн “Бэлчир” гэдэг газар Галттай нэртэйгээр 240 өрх, 2039 хүн амтай Буриад иргэдийн хүсэлтээр байгуулагджээ. Түүнээс хойш сумын төвийг 1925 онд Карников тосгонд, 1953 онд одоогийн Тавинд шилжүүлжээ.

Ерөө сум 820.3 мянган га нутаг дэвсгэртэй. Сэлэнгэ аймгийн нийт газар нутгийн 19.7 хувийг эзэлдэг бөгөөд аймгийн нийт хүн амын 6.7% хувь нь оршин сууж байна. Хүн амын нягтрал нь 1 га талбайд 8.8 хүн ногддог. Хүн амын тоогоор Сэлэнгэ аймгийн 17 сумаас эхний 5-д, газар нутгийн хэжээгээр 1 дүгээрт ордог сум юм.



- Улаанбаатар хотоос 320км, аймгийн төвөөс 86км, Дархан-уул аймгаас 84км, Төмөр замын Дулаанхан (Ерөө) өртөөнөөс 45км, Хүдэр сумаас 78км, Жавхланта сумаас 45км авто машины засмал замтай.
- Төмөр замын Дулаанхан өртөөнөөс БТЕГол компанийн Хандгайт өртөө хүртэл 117 км төмөр замтай.
- Сумын төв болон тосгондоо нийт 3,3 км засмал замтай
- Үүрэн холбооны Мобиком, Юнител, Скайтел, Жи-мобайлийн сүлжээ нэвтэрсэн
- Дархан-уул аймгаас 110 квт-ын өндөр хүчдэлийн шугамаар тэжээгддэг дэд бүтэц сайн хөгжсөн
- Гадаад дотоодын арилжаа худалдаа, хөрөнгө оруулалт хийх, үйлдвэрлэл эрхлэх бүрэн боломжтой.
- Нутаг дэвсгэрийн 70 гаруй хувийг ой мод, 20 хувийг бэлчээр, 3 хувийг хадлангийн талбай эзэлдэг.
- Төсвийн тухай хуулийн хүрээнд цалин түүнтэй адилтгах орлогын суутган орон нутагтаа төвлөрдөг болсноор 2022 онд 2198,2 сая төгрөг, 2023 оны эхний 3-р улирлын байдлаар 4432,7 сая төгрөгийн орлого орсон байна. Мөн сумын ойн сан бүхий газар нутгаас орсон ойн дагалт баялгийн нөөцийн орлого 2020 онд 1656,0 сая төгрөг, 2021 онд 2105,8 сая төгрөг, 2022 онд 2248,0 сая төгрөгийн орлого тус тус орж, сүүлийн хоёр жилийн хугацаанд 3186,1 сая төгрөгийг аймгийн төсөвт орлого төвлөрүүлсэн. Төсвийн болон орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажлуудыг хийж байна.
- Сумын төв болон Бугант тосгонд нийт төр төсвийн 12 байгууллага, 1 орон нутгийн өмчит газарт нийт 300 гаруй албан хаагч ажилладаг.
- ХААН банк, Төрийн банк, Сендли ББСанхүүгийн байгууллага байнгын үйл ажиллагаа явуулдаг.



- Олон улсын стандартад нийцсэн 960 хүүхдийн сургуулийг хувийн хэвшил өөрийн хөрөнгөөр барьж байгуулан байнгын ашиглалтанд хүлээлгэн өгсөн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 200 хүүхдийн цэцэрлэгийг шинээр барьж байгуулсан нь шилжин суурьшиж буй иргэдийн хүүхэд багачууд ая тухтай, таатай орчинд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролыг бүрэн эзэмших боломж бүрдсэн.
- MNS5081:2013 стандарт, ЭМСайдын А/540 тоот тушаалын А зэрэглэлээр тусламж үйлчилгээ үзүүлэх бүтэц зохион байгуулалтаар, амбулаторийн хэсэг, хэвтэн эмчлүүлэх хэсэг, дэмжих үйлчилгээний хэсгүүдээр тус тус зохион байгуулсан сум дундын эмнэлэгтэй.

## 1. ТУС СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ:

- Ерөө сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл бол газар тариалан, мал аж ахуй, модны аж ахуй, уул уурхай юм.
  - МАК агро ХХК нь мах болон малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулах эхлэлийг тавьсан нь сумын иргэдийг байнгын ажлын байраар хангах, малчид мал бүхий иргэдийн малыг эргэлтэд оруулах, эрүүл малын махыг гадаад худалдаанд гаргах зэрэг томоохон ажил хийгдэх нөхцөл бүрдэж байна.
  - Монгол Улсын төмөрлөгийн томоохон үйлдвэрлэгч "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-н тус сумын Буурагчин багийн нутаг дэвсгэр Баянгол хэсэгт үйл ажиллагаагаа явуулж төмрийн хүдэр олборлож байна. Тус байгууллагын нийт ажиллагсдын 50 хувийг орон нутгийн иргэд эзэлж байна
  - Байгалийн үзэсгэлэн бүрдсэн, цаг уурын таатай байдлаас хамааран аялал, жуулчлалын үйлчилгээ, байгалийн баялгийг түшиглэсэн уул уурхайн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн чиглэлийн агропарк, жижиг үйлдвэрүүдийг байгуулах боломж бүрдсэн.

## 2. ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ БОЛОН ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АЖИЛ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ:

- Сум, орон нутгийн цаашдын хөгжил дэвшилтэй холбоотойгоор дунд хугацааны бодлогын бичиг баримт болох "Сумын хотын хөгжлийн төлөвлөгөө"-г төсвийн 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байна.
- Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулан хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.
- Ерөө сумын төвөөс Бугант тосгоны чиглэлийн хатуу хучилттай 27,8 км авто зам шинээр тавигдана.
- Соёлын төвийн барилга /400 хүний суудалтай/ шинээр баригдана.
- Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл баригдана.

Танай сумыг зорин ирэх иргэдэд ямар таатай нөхцөл боломж олгох вэ?

- Аялал жуулчлал, хөдөө аж ахуйн чиглэлийн үйлдвэрлэлийн агропарк, жимс, жимсгэнийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж газар эзэмших, ашиглах асуудлыг төрийн зүгээс хуулийн хүрээнд шийдвэрлэж ажиллана. Мөн шилжин суурьшиж буй иргэдийн газар өмчлөлийн асуудлыг шуурхай шийдвэрлэнэ.
  - Зам харилцаа сайн хөгжсөнтэй холбоотойгоор худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх боломжтой.
  - Эрчимжсэн мал аж ахуй, газар

